

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ
ОРОН НУТГИЙН ӨМЧИТ БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГАТАЙ
БАЙГУУЛАХ ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭ

2026 оны 2 дүгээр сарын 25

Дугаар: 01/30

Улаанбаатар хот

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү гэрээний зорилго нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн хөгжлийн 2026 оны төлөвлөгөө, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/62 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын "2026 оныг Бизнес эрхлэгчдийг дэмжих жил болгон зарлах тухай" 2026 оны А/01 дүгээр захирамжийн дагуу хэрэгжүүлж байгаа арга хэмжээг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган, үндэсний үйлдвэрлэгч, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч, бүтээн байгуулагч зэрэг бизнес эрхлэгчдийг бүх талаар дэмжих, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэх, шударга, ил тод, хариуцлагатай, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлж, ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг чангатгаж, иргэдэд хүргэх төрийн болон нийгмийн үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэх, хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхой болгож, эцсийн үр дүнг үнэлж, гэрээг дүгнэхтэй холбогдох харилцааг зохицуулахад оршино.

1.2.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийг удирдлага болгон нэг талаас Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар (цаашид "Нийслэлийн Засаг дарга" гэх), нөгөө талаас "Багачууд хүнс" ОНӨААТҮГ-ын захирал Б.Мөнхнасан нар (цаашид "Удирдах ажилтан", хамтад нь "Талууд" гэх) 2026 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал 1 жилийн хугацаатайгаар энэхүү гэрээг байгуулав.

1.3.Талууд Засгийн газрын гишүүнтэй Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2026 онд хамтран ажиллах гэрээ, Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор баталсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам", Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан "Хяналт-шинжилгээ хийх журам", Засгийн газрын 2025 оны 183 дугаар тогтоолоор баталсан "Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих нийтлэг журам",

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны "Нийслэлийн 2026 оны төсөв батлах тухай" 25/133 дугаар тогтоол болон энэхүү гэрээний хугацаанд баталсан хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолыг тус тус хэрэгжүүлж ажиллана.

1.4.Монгол Улсын Засгийн газраас 2026 оныг "Боловсролыг дэмжих жил" болгон зарласантай холбогдуулан "Эрдэм боловсролтой Монгол хүн" зорилгыг хэрэгжүүлэх, тэгш, хүртээмжтэй, чанартай боловсролын нэгдсэн тогтолцоог бэхжүүлэх зорилгоор холбогдох талуудтай уялдааг хангаж, шуурхай хамтран ажиллана.

1.5.Нийслэлийн Засаг даргын 2026 оныг "Бизнес эрхлэгчдийг дэмжих жил болгон зарлах тухай" А/01 дүгээр захирамжийн дагуу хэрэгжүүлж байгаа арга хэмжээг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган, үндэсний үйлдвэрлэгч, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч, бүтээн байгуулагч зэрэг бизнес эрхлэгчдийг бүх талаар дэмжиж ажиллана.

1.6.Байгууллагын "гүйцэтгэлийн төлөвлөгөө" нь энэхүү гэрээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг бөгөөд түүнд төсвийн шууд захирагчаас тухайн жилд өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ, төсөв, шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшин, хугацаа, хариуцах нэгжийг тусгана.

Хоёр.Удирдах ажилтны хүлээх үүрэг

2.1.Удирдах ажилтан энэхүү гэрээгээр дараах үүрэг хүлээнэ:

2.1.1.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, 2026-2030 онд Нийслэлийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд тусгагдсан өөрийн байгууллагын чиг үүрэгт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, холбогдох журамд заасан хугацаанд тайлагнах;

2.1.2.Засгийн газрын гишүүнтэй Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч 2026 онд хамтран ажиллах гэрээнд туссан арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, гэрээнд заасан хугацаанд тайлагнах;

2.1.3.Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж, байгууллагын үйл ажиллагаандаа хиймэл оюун ухааныг нэвтрүүлэх замаар хүний нөөцийг цомхон, тогтвортой, үр ашигтай, хариуцлагатай ажиллуулах, чадахуйн зарчим (мерит)-ыг тууштай хэрэгжүүлэх;

2.1.4.байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөж, төсвийн зардлыг батлагдсан төсвийн хүрээнд хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах, өр, авлага үүсгэхгүй байх, байгууллагын өмч, хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах, нийслэлийн төсөвт төвлөрүүлэх ногдол

ашгийн төлөвлөгөөний болон түүнтэй холбоотой гэрээ, хэлцлийн биелэлт, үр дүнг тайлагнаж, Нийслэлийн Засаг даргын өмнө хариуцлага хүлээх;

2.1.5.Төсвийн тухай хуулийн дагуу санхүүгийн тайланг улирал, хагас жил, бүтэн жилээр хугацаанд нь тайлагнах;

2.1.6.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, “Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”, нийслэлийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлагатай байгуулсан “Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ”-ээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх;

2.1.7.хууль, дүрмээр болон энэхүү гэрээгээр хүлээсэн чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж, Нийслэлийн Засаг даргыг шүүхийн маргаанд итгэмжлэлээр төлөөлөх, үр дүнг хариуцан тайлагнах;

2.1.8.Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль болон хотын аж ахуйн нэгдмэл байдлыг хангах чиг үүргийн хүрээнд хотын аж ахуй, инженер хангамжийн чиглэлийн төсөл, хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилтийг Улаанбаатар хотын Ерөнхий менежертэй зөвшилцөж ажиллах;

2.1.9.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Нийслэлийн Засаг дарга баталж мөрдүүлэх захиргааны хэм хэмжээний актыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн боловсруулж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт ирүүлэх, батлагдсан дүрэм, журам, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах;

2.1.10.дүрмээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж бодит үр дүнг дээшлүүлэх, тогтоосон хугацаанд тайлагнах;

2.1.11.албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

2.1.12.алба хаагчдын сахилга хариуцлага, хандлага, ёс зүй, мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэхэд онцгой анхаарал хандуулж ажил, арга хэмжээ зохион байгуулах;

2.1.13.төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, шуурхай, чирэгдэлгүй байх нөхцөлийг бүрдүүлэн, үр дүнг нэмэгдүүлэх;

2.1.14.холбогдох хууль тогтоомжийн хүрээнд нийслэлийн удирдлагын шийдвэр, удирдамжийн дагуу хийгдэж буй албаны, хэсэгчилсэн, гүйцэтгэлийн шалгалтын үеэр хяналт хэрэгжүүлэх нэгж, албан тушаалтны хууль ёсны шийдвэрийг биелүүлэх;

2.1.15.Нийслэлийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 31-ний А/1024 тоот захирамжаар батлагдсан хотын хөгжлийн индексийг тооцох 86 үзүүлэлтээс өөрийн байгууллагын чиг үүрэгт хамаарах үзүүлэлтүүдийн суурь түвшинг тодорхойлж, үзүүлэлтийн үр дүнг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө

боловсруулан хэрэгжүүлэх бөгөөд хэрэгжилтийн хүрсэн үр дүнг жилийн эцсийн байдлаар шинэчлэн тооцож тайлагнах, 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх;

2.1.16.чиг үүргийн хүрээний үндэсний болон хотын стандарт, нормын хэрэгжилтийг хариуцан, иргэн, хуулийн этгээдэд сурталчлан таниулж мөрдүүлэх, хяналт тавих, тухай бүр тайлагнаж бодит үр дүнг сайжруулах;

2.1.17.байгууллага, аж ахуй нэгж, албан хаагчдын төлөвлөлтийн баримт бичгийг тогтвортой хөгжилд түшиглэсэн засаглалын шинэчлэлийн хүрээтэй уялдуулан боловсруулах, хэрэгжилтийг хангах, хэрэгжилтийн явц, үр дүнг тогтмол хянах, залруулах арга хэмжээг тухай бүр авч ажиллана;

2.1.18.аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэн хариуг шуурхай өгөх, хүнд суртал, чирэгдэлгүй зохион байгуулж, тодорхой арга хэмжээ авах;

2.1.19.Нийслэлийн удирдлагуудаас өгсөн үүрэг, даалгаврыг нэн даруй биелүүлж, явц үр дүнг тайлагнах, Нийслэлийн удирдлага, Засаг даргын Тамгын газраас хүргүүлсэн чиглэл, албан бичгийн хариуг шуурхай өгөх, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

2.1.20.энэхүү гэрээний хавсралт болох "Байгууллагын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"-нд тусгагдсан нийт арга хэмжээний биелэлтийг арга хэмжээ нэг бүрээр хэрэгжүүлэн холбогдох журамд заасан хугацаанд тайлагнах;

2.1.21.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан Нээлттэй мэдээлэл, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 46 дугаар зүйлд заасан байгууллагын даргын шийдвэр, байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, холбогдох шийдвэр гарснаас хойш ажлын гурван өдрийн дотор бүрэн эхээр нь цахим хуудаст байршуулж, олон нийтийг танилцах боломжоор хангах;

2.1.22.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Шилэн дансны тухай хуульд заасан төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангаж, шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээ, мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцах;

2.1.23.гадаад харилцааны чиглэлийн үйл ажиллагаа, арга хэмжээний талаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцааны газраас урьдчилан зөвшөөрөл авч, хэрэгжүүлэх;

2.1.24.хариуцсан чиг үүргийн хүрээний асуудлаар хэрэгжүүлж байгаа аливаа арга хэмжээний талаарх мэдээллийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэстэй зөвшилцөж, мэдээллийг нэгдсэн нэг урсгалаар түгээх;

Гурав.Нийслэлийн Засаг даргын хүлээх үүрэг

3.1.Нийслэлийн Засаг дарга энэхүү гэрээгээр дараах үүрэг хүлээнэ:

3.1.1.Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний бүх шатны агентлаг, харьяа байгууллагын ажлын уялдаа холбоог хангаж, төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан үйлчилгээний шуурхай, чирэгдэлгүй байх нөхцөлийг бүрдүүлж, хариуцлагыг сайжруулах чиглэлээр зохих арга хэмжээг авах;

3.1.2.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Нийслэлийн Хөгжлийн 2026 оны төлөвлөгөөг хэрэгжүүлж байгаа байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, хэрэгжилтийг хангах ажлыг нэгдсэн удирдлагаар хангах;

3.1.3.Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, байгууллагын үйл ажиллагааг тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллуулах, байгууллагын сахилга, хариуцлагыг дээшлүүлэх арга хэмжээ авах;

3.1.4.харьяа байгууллагуудад төсвийн зардлыг хэмнэх, төсвийн зарлагын үр өгөөжийг нэмэгдүүлэх, улс, орон нутгийн төсөв болон бусад эх үүсвэрээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний чанар, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулж, удирдлага, зохион байгуулалтаар хангах;

3.1.5.худалдан авах ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хугацаанд нутгийн захиргааны байгууллагуудад тогтмол зөвлөмж, чиглэл өгч, сургалт, мэдээллээр хангах;

3.1.6.тухайн төрийн байгууллага болон эрх шилжүүлсний үндсэн дээр бусад байгууллагын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний санхүүжилтийг хуулийн хугацаанд олгох;

3.1.7.төрийн үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий харьяа байгууллагын удирдлагатай байгуулсан гэрээг дүгнэхэд тухайн удирдах ажилтны иргэдэд цахимаар үзүүлсэн үйлчилгээний тоо, чанар, хүртээмжийг харгалзах, үйлчилгээ үзүүлэх үүргээ хангалтгүй биелүүлсэн удирдах ажилтанд холбогдох хуульд заасны дагуу хариуцлага тооцох;

3.1.8.ил тод, хэмнэлттэй, үр ашигтай төсвийн бодлогыг хэрэгжүүлж, төсвийн сахилга батыг чангатгах, төсвийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангуулах.

Дөрөв.Гэрээг дүгнэх

4.1. Гэрээний биелэлтийн хагас жилийн тайланг 2026 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор, бүтэн жилийн тайланг 2026 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тус тус ирүүлнэ.

Тав. Гэрээний хариуцлага

5.1. Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн, гэрээний хавсралт болох "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө"-нд тусгагдсан арга хэмжээг дутуу гүйцэтгэсэн, өмнөх үр дүнг бууруулсан, хүрэх түвшинд хүргээгүй, сахилга, хариуцлага алдсан, ёс зүйн зөрчил гаргасан бол Хөдөлмөрийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлагыг хүлээлгэх үндэслэл болно.

Зургаа. Бусад зүйл

6.1. Талууд гэрээнд тусгагдсан үүргээ харилцан биелүүлнэ.

6.2. Гэрээг хэрэгжүүлэх боломжгүй болсон тохиолдолд талууд харилцан бичгээр санал тавьж, зөвшилцөн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

6.3. Гэрээнд өөрчлөлт орсон тохиолдолд гэрээг баталгаажуулан гарын үсэг зурж, хоёр хувь үйлдэх бөгөөд энэхүү өөрчлөлт нь энэ гэрээний нэгэн адил хүчин төгөлдөр үйлчилнэ.

6.4. Энэхүү гэрээг 2 хувь үйлдэж, талууд тус тус 1 хувийг хадгална.

Гэрээ байгуулсан:

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

"БАГАЧУУД ХҮНС" ОРОН НУТГИЙН
ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ
ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ



Б.МӨНХНАСАН